

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ.....	3
2.	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн	7
2.8.1	Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7
2.8.2	Авлага	8
2.8.3	Урьдчилгаа.....	8
2.8.4	Бараа материал.....	9
2.8.5	Үндсэн хөрөнгө	10
2.8.6	Өр төлбөр	11
2.8.7	Засгийн газрын хувь оролцоо	11
2.9	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	12
2.10	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	13
2.11	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	15
2.12	Шилэн дансны мэдээлэл.....	15
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	16
2.14	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	16
3.	Менежментийн захидал	17
3.1	Батлагдсан төсөв гүйцэтгэлтэй холбоотой асуудал	17
3.2	Түүврийн байгууллагатай холбоотой асуудал	17
3.3	Харьяа байгууллагуудтай холбоотой асуудал.....	18
4.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
4.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	19
4.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	20
4.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	21
4.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	22
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	23
4.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	24
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	25
5.1	Албан шаардлага	26
5.2	Алдаа, зөрчлийн нэгтгэл	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОХЗТЛ	Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори
БЦГХЗ	Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
ДЦГХЗ	Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
СГЗ	Сав газрын захиргаа
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТӨХ	Төрийн өмчийн хороо /хуучин нэрээр/
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УЦУОШТ	Ус, цаг уур орчны шинжилгээний төв
УЦУОСМХ	Ус, цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
УТХГХЗ	Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД Н.ЦЭРЭНБАТ
ТАНАА

2020.04.24 № 1323
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн харьяа байгууллагуудын авлага, өглөгийг барагдуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, бүртгэл тайлагналыг холбогдох стандарт, журмын дагуу хэрэгжүүлэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 8-наас 2020 оны 4 дүгээр сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Болормаа, аудитор Э.Энхбаатар нар гүйцэтгэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 01/2168 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын бодлого, стратегийг улс орны эдийн засаг, төсөв, санхүүгийн нөөц, олон улсын хамтын ажиллагааны бодлоготой уялдуулан төлөвлөж хэрэгжүүлэх, энэ чиглэлд Засгийн газрын манлайллыг хангах;
- Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийг дэмжих, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээрх хувийн хэвшил, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үүсгэл санаачилга, хамтын ажиллагааг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг бодлогоор уялдуулан чиглүүлэх;
- Яам, салбарын албан хаагч, ажиллагсад байгаль хамгаалах, ногоон хөгжлийг дэмжих, аялал жуулчлалыг хөгжүүлэх, шинжлэх ухааны ололт, олон улсын тэргүүний арга туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Байгаль орчны төлөв байдал, хувьсал өөрчлөлтийн чиг хандлагыг судлан шинжлэх, байгаль орчныг хамгаалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалахтай холбогдуулан үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээнд шинжлэх ухааны ололт, ногоон технологи нэвтрүүлэхэд урамшууллын болон зохицуулалтын хөшүүрэг ашиглах ;

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох тушаал шийдвэр, стандартын өөрчлөлтийг тусгаагүй байх зэрэг үр дагавартай байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 2019 оны “Төсвийн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан 27 байгууллага, төсөл, хөтөлбөрийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн байна. Дотоод аудитаар нийт 3,725.2 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 3,467.1 сая төгрөгийн зөрчлийг залруулан, 333 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн биелэлт 80.0 хувьтай байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний

алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 105,911.8 сая төгрөгийн 2 хувь буюу 2,118.2 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2,108.0 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгосонтой холбоотой болно.

2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 16,283.4 сая, эцсийн үлдэгдэл 17,403.9 сая төгрөг болж, 1,120.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	8.0	13.2	5.2
Банканд байгаа бэлэн мөнгө	16,275.4	17,390.7	1,115.3
Дүн	16,283.4	17,403.9	1,120.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	856.4	832.8	- 23.6
ТӨҮГ болон ОНӨҮГ	15,427.0	16,571.1	1,144.1
Дүн	16,283.4	17,403.9	1,120.5

Эх сурвалж: БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн 17,390.7 сая төгрөгийн үлдэгдлийн 15.6 сая төгрөг нэмэлт санхүүжилтийн харилцах, 819.6 сая төгрөг арилжааны банкны харилцах, 16,555.5 сая төгрөг Төрийн сангийн харилцах дансанд тус тус байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн нийт 29.7 сая төгрөгийн зөрчил; /Говьсүмбэр, Дархан, Дорноговь, Дорнод аймгуудын УЦУОШТ 16.0 сая, Буйр-Мэнэнгийн талын СГЗ 8.1 сая, Дорнод ДЦГХЗ 2.2 сая, Богдхан уулын ДЦГХЗ 1.9 сая, Хяргас нуур-Завхан голын СГЗ 1.4 сая, Говийн бага ДЦГХЗ 0.1 сая, Мөнххайрханы БЦГХЗ, Сэлэнгийн голын СГЗ/
- Батлагдсан төсвийг хэтрүүлсэн, зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан, орлогын төлөвлөгөө биелүүлээгүй, зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан нийт 1,817.9 сая төгрөгийн зөрчил; /БОАЖЯ 1,800.2 сая, Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ 7.4 сая, Баянхонгор, Дундговь аймгуудын УЦУОШТ 3.1 сая, Мянган угалзтын БЦГХЗ 1.7 сая, Хан Хэнтийн УТХГХЗ 1.5 сая, Онон-Улз голын СГЗ 1.3 сая, Монгол Элсний БЦГХЗ 0.9 сая, Хар нуур- Ховд голын СГЗ 0.8 сая, Бөөнцагаан-Орог нуурын СГЗ 0.6 сая, Говийн их ДЦГ-ын Б хэсгийн ХЗ 0.2 сая, Орхон-Чулуут голын СГЗ 0.2 сая/
- Ажилчдад үр дүнгийн урамшууллыг илүү, дутуу тооцож олгосон, ээлжийн амралттай, томилолтоор ажилласан хүнд цалин давхардуулан олгосон, сахилгын шийтгэлтэй ажилчдад үр дүнгийн урамшуулал олгосон нийт 17.9 сая төгрөгийн

зөрчил; /Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дархан, Дундговь, Говь-Алтай, Говьсүмбэр, Сүхбаатар, Увс аймгуудын УЦУОШТ 15.2 сая, Дорнод ДЦГХЗ 1.3 сая, Хараа- Ерөө голын СГЗ 1.1 сая, Хэрлэн голын СГЗ 1.0 сая, Тужийн нарсны БЦГХЗ 0.2 сая, Үенч-Бодонч голын СГЗ 0.1 сая, Хүйсийн говь-Цэцэг нуурын СГЗ 0.1 сая, Тарвагатайн нурууны БЦГХЗ/

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1,800.8 сая, эцсийн үлдэгдэл 3,825.1 сая төгрөг болж, 2,024.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.6	2.5	- 0.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.2	0.2	-
Татаас, санхүүжилтийн авлага	1,324.0	3,413.4	2,089.4
Дансны авлага /ТӨҮГ/	25.6	25.6	-
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	10.8	18.6	7.8
Бусад авлага	437.6	364.8	- 72.8
Дүн	1,800.8	3,825.1	2,024.3
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1,747.2	2,816.6	1,069.4
Төсөл/ сан		947.2	947.2
Төрийн сан			-
ТӨҮГ болон ОНӨҮГ	53.6	61.3	7.7
Дүн	1,800.8	3,825.1	2,024.3

Эх сурвалж: БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жил болсон 353.0 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Засгийн газрын 2015 оны 310 дүгээр тогтоолоор татан буулгасан “Аялал жуулчлалын үндэсний төв” ТӨҮГ-ын 25.6 сая төгрөгийн авлага;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 2015 онд татан буугдсан Цэвэр агаар сангаас шилжиж ирсэн 311.5 сая төгрөгийн авлага;
- Цаг уур, орчны шинжилгээний газрын 2.2 сая төгрөгийн авлага;
- Сав газрын захиргаатай холбоотой 2016 онд 2 сав газрын захиргаа нэгдэхэд үүссэн зэрэг 13.7 сая төгрөгийн авлага;

Аудитын илрүүлэлт:

- Тайлант онд шинээр үүссэн нийт 4.4. сая төгрөгийн авлага; /Хангай нурууны БЦГХЗ 1.8 сая, Говийн их ДЦГ-ын А хэсгийн ХЗ 0.6 сая, Дорнод ДЦГХЗ 0.6 сая, Говийн их ДЦГ-ын Б хэсгийн ХЗ 0.6 сая, Орхон-Чулуутын СГЗ 0.5 сая, Хүйсийн говь-Цэцэг нуурын СГЗ 0.2 сая, Хяргас нуурын СГЗ 0.1 сая /
- Олон жил болсон нийт 9.6 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй; / Онон-Улз голын СГЗ 3.4 сая, Сэлэнгэ голын СГЗ 2.1 сая, Дундговь аймгийн УЦУОШТ 1.9 сая, Цаг уур орчны шинжилгээний газар 1.4 сая, Баянхонгор аймгийн УЦУОШТ 0.8 сая/
- Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын Төв аймгийн Эрдэнэ сумын хомсдол, доройтолд өртсөн ойд ойн цэвэрлэгээний ажил гүйцэтгэхэд 7.9 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон боловч гүйцэтгэгч Үндэсний ойжилт ХХК гэрээт ажлыг гүйцэтгээгүй

2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 8,435.2 сая, эцсийн үлдэгдэл 29,720.3 сая төгрөг болж, 21,285.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	8,425.3	29,717.3	21,292.0
Томилолтын урьдчилгаа	9.9	3.0	- 6.9
Дүн	8,435.2	29,720.3	21,285.1
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	8,433.3	29,676.2	21,242.9
Төсөл/ сан	-	5.6	5.6
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	1.9	38.5	36.6
Дүн	8,435.2	29,720.3	21,285.1

Эх сурвалж: БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд тайлант онд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны 19/01 тогтоолд тусгасан агаар, орчны бохирдлыг бууруулахад зориулж хэрэгжүүлж байгаа 32 ажлын урьдчилгаа санхүүжилт 28,781.4 сая, Туул голын сав газрын захиргааны хэрэгжүүлж байгаа “Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир усыг биотехнологийн аргаар цэвэрлэх төсөл”-ийн урьдчилгаа санхүүжилт 548.8 сая төгрөг, 4 байгууллагатай холбоотой 99.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

2014-2017 онд үүссэн 288.1 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээний төлбөрүүд байна. Үүнд:

- Ойжуулалт хөтөлбөрөөс 2014 онд төлсөн 195.6 сая төгрөгийн урьдчилж гарсан зардал;
- Койкагийн төслийн хөрөнгөөр баригдаж байгаа сургалтын төвийн дулаан, усан хангамжийн угсралтын ажлын санхүүжилтэд 2017 онд олгосон 92.5 сая төгрөг, сургалтын төвийг 2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүлээлгэн өгөх гэрээтэй.

2.8.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 8,283.8 сая, эцсийн үлдэгдэл 9,405.5 сая төгрөг болж, 1,121.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	3,314.2	4,167.3	853.1
Дуусаагүй үйлдвэрлэл	21.4	354.4	333.0
Бэлэн бүтээгдэхүүн	32.3	4.1	- 28.2
Хангамжийн материал	4,828.1	4,736.6	- 91.5
Биологийн хөрөнгө	23.1	63.0	39.9
Мал амьтад	64.7	80.1	15.4
Дүн	8,283.8	9,405.5	1,121.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	8,150.0	8,919.4	769.4
Төсөл/ сан	-	5.3	5.3
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	133.8	480.8	347.0
Дүн	8,283.8	9,405.5	1,121.7

Эх сурвалж: БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материал худалдан авсан 5,727.6 сая, хандиваар авсан 362.8 сая, шилжүүлэн авсан 2,138.4 сая төгрөгөөр нэмэгдэж, худалдсан, зарцуулсан 4,474.7 сая, шилжүүлсэн 2,630.8 сая төгрөгөөр хасагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 15,008.1 сая, агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн батлагдсан төсвөөс худалдан авсан 13,075.9 сая төгрөгийн хөрөнгө бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолд заасны дагуу албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад хамаарахгүй этгээд автомашин ашигласан, автомашины 100 км-т зарцуулах шатахууны норм, нормативыг хэтрүүлсэн, шатахууны тооцоо хийгээгүй, тайлан гаргаагүй нийт 9.9 сая төгрөгийн зөрчил;/Ховд аймгийн УЦУОШТ 2.5 сая, Онон-Улз голын СГЗ 2.3 сая, Монгол Элсний УТХГХЗ 1.5 сая, Орхон Чулуут голын СГЗ 1.5 сая, Дорнод ДЦГХЗ 1.2 сая, Богдхан уулын ДЦГХЗ 0.4 сая, Говийн их ДЦГ-ын А хэсгийн ХЗ 0.1 сая, Хараа Ерөө голын СГЗ/
- Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргаа ЗДТГ-ын хуучин конторын барилгыг өөрийн байгууллагын контор болгож засвар хийлгэх явцад засварын материалын тооцооноос 0.2 сая төгрөгийг илүү зарцуулсан.

2.8.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 60,644.1 сая, эцсийн үлдэгдэл 62,876.0 сая төгрөг болж, 2,231.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	28,035.4	30,723.3	2,687.9
Авто тээврийн хэрэгсэл	4,641.7	4,554.9	- 86.8
Машин тоног төхөөрөмж	7,029.0	6,955.4	- 73.6
Тавилга эд хогшил	1,285.2	1,084.9	- 200.3
Зам гүүрийн барилга байгууламж	4.7	2.3	- 2.4
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	0.8	0.7	- 0.1
Түүх соёл, музейн зүйлс	1,232.8	1,232.8	-
Бусад үндсэн хөрөнгө	1,305.6	1,310.9	5.3
Ном	26.2	13.5	- 12.7
Программ хангамж	110.2	87.9	- 22.3
Бусад биет бус хөрөнгө	16,972.5	16,909.4	- 63.1
Дүн	60,644.1	62,876.0	2,231.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	51,683.9	53,558.5	1,874.6
Төсөл/ сан	-	96.1	96.1
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	8,960.2	9,221.4	261.2
Дүн	60,644.1	62,876.0	2,231.9

Эх сурвалж: БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,755.9 сая, балансас баланст шилжүүлэн авсан 3,760.3 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 2,958.6 сая, дахин үнэлгээний нэмэгдэл 30.9 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансас баланст шилжүүлсэн 2,008.6 сая, худалдсан 163.3 сая, акталсан 778.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/485 тушаалаар харьяа 39 байгууллагад хуваарилсан Mitsubishi Pick up L200 суудлын автомашиныг данс бүртгэлд тусгаагүй;
- Хөрөнгийн тооллого хийгээгүй, ангиллыг буруу бүртгэсэн, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглах боломжгүй хөрөнгийг актлаагүй, акталсан хөрөнгийг устгал хийж данс бүртгэлээс хасаагүй нийт 191.9 сая төгрөгийн зөрчил; /Говийн их ДЦГ-ын А хэсгийн ХЗ, Богдхан уулын ДЦГХЗ, Говийн бага ДЦГХЗ, Умард говийн гүвээт-Халхын дундад талын СГЗ, Баянхонгор, Булган, Дорноговь, Дорнод, Увс, Ховд, Говьсүмбэр аймгуудын УЦУОШТ/

- ТӨБЗГ болон орон нутгийн өмчийн газраас зохих зөвшөөрөл авалгүй хөрөнгө бэлтгэсэн, шилжүүлсэн; /Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ, Умард говийн гүвээт-Халхын дундад талын СГЗ, Ховд аймгийн УЦУОШТ/

2.8.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 15,400.1 сая, эцсийн үлдэгдэл 17,757.7 сая төгрөг болж, 2,357.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр дүн	754.7	614.3	- 140.4
Ажилчидтай холбогдсон өглөг	17.6	8.4	-9.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.8	4.6	3.8
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	0.5	4.0	3.5
Бусад өглөг	735.8	597.3	-138.5
Урьдчилж орсон орлого	14,645.4	17,143.4	2,498.0
Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	14,037.2	16,354.0	2,316.8
Бусад урьдчилж орсон орлого	608.2	789.4	181.2
Нийт дүн	15,400.1	17,757.7	2,357.6
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	14,637.1	16,702.4	2,065.3
Төсөл, сан	-	24.3	24.3
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	763.0	1,031.0	268.0
ДҮН	15,400.1	17,757.7	2,357.6

Эх сурвалж: БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Засгийн газрын 2015 оны 310 дугаар тогтоолоор татан буулгасан “Аялал жуулчлалын үндэсний төв” ТӨҮГ-ын 32.7 сая, төгрөгийн өглөг, Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2014 оноос үүссэн 54.4 сая, ойжуулалт хөтөлбөрийн 2014 онд үүссэн 263.6 сая төгрөгийн олон жилийн насжилттай өглөг байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэлд 2006 оноос үүссэн байгалийн нөхөн сэргээлтийн баталгаа дансны үлдэгдэл 16,354.0 сая төгрөгийн орлого байна.

Аудитын илрүүлэлт:

- Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны даргаар ажиллаж байсан хүний цалинг нөхөн олгохдоо 1.4 сая нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцсон боловч цалинг нийгмийн даатгалын хэлтэст мэдээлээгүй, нягтлан бодох бүртгэлд өглөгөөр бүртгээгүй;
- Баянхонгор аймгийн УЦУОШТ Сангийн сайдын 388 дугаар тушаалын батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” журмын 3.6-ын б “Байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг бусад өглөгт шилжүүлэн бүртгэнэ” гэсэн журмыг мөрдөөгүйгээс цалингаас суутгасан НДШ, ХХОАТ-аас бусад суутгалын 104.0 сая төгрөгийг “Бусад өглөг”-ийн дансаар бичилт хийлгүй “Цалингийн өглөг” дансанд бичилт хийсэн;

2.8.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 91,137.3 сая, эцсийн үлдэгдэл 133,558.6 сая төгрөг болж, 42,421.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	43,596.3	43,627.2	30.9
Өмч /төрийн/ ТӨҮГ	8,087.2	8,087.2	-

Хуримтлагдсан үр дүн	32,809.7	75,235.5	42,425.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,644.1	6,608.7	- 35.4
Дүн	91,137.3	133,558.6	42,421.3
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	81,894.5	122,925.0	41,030.5
Төсөл, сан	-	1,029.9	1,029.9
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	9,242.8	9,603.7	360.9
Дүн	91,137.3	133,558.6	42,421.3

Эх сурвалж: БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс 30.9 сая төгрөгөөр өссөн нь “Монгол Ус” ТӨААТҮГ эзэмших эрхийн гэрчилгээтэй 955 м.кв газрыг дахин үнэлж биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэснийг 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулсан.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөд хийгдсэн 3,952.8 сая төгрөгийн залруулгад дахин үнэлгээтэй хөрөнгө акталсан 9 байгууллагын 44.0 сая, “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨҮГ нь хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан, нотлогдоогүй өглөг 46.7 сая, данс бүртгэлд тусгаагүй үндсэн хөрөнгийн 4.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, Сангийн яам руу шилжсэн 8 төслийн 1,949.6 сая, БОАЖЯ-ны хөтөлбөр арга хэмжээний тусдаа дансыг үндсэн данс руу хаасан хаалтын бичилтийн 2,098.0 сая төгрөгөөр буурсан байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 142,761.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 74,257.2 сая төгрөгийг урсгал зардалд, 19,504.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 49,000.0 сая төгрөгийг дотоод эх үүсвэрээс олгох зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 142,465.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 295.5 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 134,162.3 сая төгрөгийг улсын төсвөөс олгож, 8,303.6 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 354.7 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 87.8 сая төгрөгөөр давсан нь байгалийн цогцолборт газар, дархан цаазат газарт зорчих жуулчдын нэвтрэх тасалбарын орлого нэмэгдсэн;

Туслах үйл ажиллагааны орлого 83.9 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 55.3 сая төгрөгөөр давсан нь Цаг уур, орчны шинжилгээний газруудын цаг агаарын мэдээний орлого, ойн үрийн орлого, нөхөн төлбөрийн зэрэг орлого нэмэгдсэнээс тус тус шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 134,586.9 төгрөг буюу 94.3 хувьтай, 8,174.5 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна.

Батлагдсан төсвөөс эдийн засгийн ангиллаар материаллаг дүнтэй дутуу зарцуулсан дараах зардлууд байна. Үүнд:

Бараа, ажил үйлчилгээний зардал 1,089.6 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг дутуу зарцуулсан;

Дотоод эх үүсвэрээс олгох зээлийн зардлын төсөв 49,000.0 сая төгрөгөөс сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх, цэцэрлэг, сургуулийн нам даралтын зуухыг хийн зуухаар солих, цахилгаан бага зарцуулдаг бойлуур, усан халаалтын бага, дунд оврын зуухны утааны хийн шүүлтүүр, угаарын хий мэдрэгч, гэр хорооллын айл өрхийн шөнийн тариф, ногоон зээлийн хүүгийн зардлын хөнгөлөлт зэрэг зардлыг санхүүжүүлэхээр холбогдох яам, байгууллагуудад шилжүүлсэн;

Хөрөнгө оруулалтын 19 төсөл, арга хэмжээнд 13,726.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 12,018.4 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/67 дугаар тушаалаар аймаг, нийслэлийн Засаг дарга, төсвийн төвлөрүүлэн захирагч нарт 11 төсөл арга хэмжээний эрхийг шилжүүлэн, 6,712.0 сая, ажил гүйцэтгэгч байгууллагад гүйцэтгэлээр 5,149.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, 157.2 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Тайлант онд төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс 1,000.0 сая төгрөгийн Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхгийн байр барих зөвшөөрлийг Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Архитектур төлөвлөлтийн даалгаврын дагуу барилгын эскиз зургийг гүйцэтгүүлэн, ТӨБЗГ-т гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарласан боловч шаардлагад нийцсэн тендер ирээгүй шалтгаанаар хийгдээгүй байна.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар 5,997.1 сая, гадаад төсөл хөтөлбөрөөс 1,210.7 сая, Засгийн газрын нөөц сангаас 926.2 сая, дээд шатны төсвийн захирагчаас 1,954.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,135.1 сая, нийт 11,223.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, үйлчилгээний зардалд 7,417.1 сая, бусад урсгал шилжүүлгийн зардалд 111.5 сая, хөрөнгийн зардалд 235.5 сая, нийт 7,764.1 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 17,489.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 1 төвлөрүүлэн захирагч, 80 төсвийн байгууллага, 4 төрийн өмчит аж ахуйн нэгж, 1 тусгай сан, 2 төслийн нэгжийн, хөрөнгө оруулалт, их засварын 1, ойн ангийн 1, нөхөн сэргээлтийн баталгааны 1, нийт 91 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 78 байгууллага аудитад хамрагдсан, 12 байгууллагад итгэл үзүүлсэн, аудитад хамрагдаагүй 1 байгууллага байна.

Аудитад хамрагдаагүй “Аялал жуулчлалын үндэсний төв” ТӨҮГ-ыг Засгийн газрын 2015 оны 310 дугаар тогтоол, ТӨХ-ны даргын 2015 оны А/158, ТӨБЗГ-ын даргын 2016 оны А/41 дүгээр тушаалуудаар татан буулгах шийдвэр гарсан боловч хэрэгжүүлээгүй, эзэмшиж байсан хөрөнгийг зохих журмын дагуу шилжүүлээгүй байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 13 байгууллагыг түүвэрт хамруулж, 65 байгууллагад дүгнэлт хүргүүлжээ. Үүнд: “Зөрчилгүй” 63, “Хязгаарлалттай” 1 /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/, “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” 1 /Монгол Кувейтын байгаль хамгаалав төв ТӨҮГ/ дүгнэлт өгсөн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,764.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,187.3 сая төгрөгийн алдааг залруулж, 553.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, “Хязгаарлалттай” дүгнэлт авсан албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 23.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа 3 байгууллагын аудит хийсэн санхүүгийн тайлангаас 449.0 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагын санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн;

Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн төсвийн зардлыг бараа, үйлчилгээний бусад зардлын ангилалд 738.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тайлагнасан.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагын санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн;

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд ойн ангийн ойжуулалт хөтөлбөрийн 2014 оны санхүүгийн тайлангийн урьдчилж гарсан зардал 195.6 сая, байгууллагад төлөх 293.3 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй, нийт 64.1 сая төгрөгийн хөрөнгө, өр төлбөртэй "Аялал жуулчлалын үндэсний төв" ТӨҮГ-ыг Засгийн газрын 2015 оны 310 дугаар тогтоол, ТӨХ-ны даргын 2015 оны А/158, ТӨБЗГ-ын даргын 2016 оны А/41 дүгээр тушаалуудын дагуу татан буулгаж, эзэмшиж байсан хөрөнгийг зохих журмын дагуу шилжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн;

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны үлдэгдэл 16,354.0 сая төгрөг байгаа боловч төсөл хэрэгжүүлэгч бүрээр төвлөрүүлэх орлого, гүйцэтгэлийн нэгдсэн бүртгэлгүй. Мөн төсөл хэрэгжүүлэгчийн төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, биелэлтийг тайлагнах батлагдсан маяггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9-д ".....сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Өмнөх онд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн;

Төсвийн ерөнхийлөн захирагчид 23.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитаар нийт 3.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1.8 сая төгрөгийн алдааг залруулж, 1.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 80 байгууллагаас 12 байгууллагад итгэл үзүүлж, 12 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, "Зөрчилгүй" 60, "Хязгаарлалттай" 1 дүгнэлт өгсөн.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо нь иргэдийн агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн ногоон төсөл, үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгосон санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" тухай заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй тул Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төсвийн шууд захирагчид "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 16,014.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 13,956.6 сая төгрөгийн алдааг залруулж, 24.8 сая төгрөгийн зөрчилд 28 төлбөрийн акт тогтоож, 1,807.1 сая төгрөгийн зөрчилд 21 албан шаардлага, 226.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 68 зөвлөмж өглөө.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны 19/01 тогтоолоор баталсан төсөл, арга хэмжээний хүрээнд худалдан авсан 13,075.9 сая төгрөгийн хөрөнгө, тоног төхөөрөмжийг урьдчилж гарсан зардлаар бүртгэж, хөрөнгөөр бүртгээгүйг төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын явцад залруулж данс бүртгэлд тусгуулсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санхүүгийн тайлангийн аудитаар “Агаар орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн ногоон зээлийн хүүгийн зардлыг санхүүжүүлэх зорилгоор арилжааны банкнуудад байршуулсан зээлийн хүүгийн хөнгөлөлтийн санхүүжилтийн ашиглаагүй үлдэгдэлд хүү нөхөн тооцуулах, ногоон зээлийн бүтээгдэхүүнд олгосон зээлийн тайлан мэдээг гаргах, зарцуулалтыг тооцоо нийлж акт үйлдэх” талаар өгсөн 1,766.3 сая төгрөгийн албан шаардлагын биелэлтийг 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 03/2418 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн шууд захирагчид хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төрийн өмчит 3 аж ахуйн нэгж байгууллагаас 1 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, “Зөрчилгүй” 1, “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” 1 дүгнэлт өгсөн.

Бэлэн мөнгөний болон бараа материалын тайлан гаргаагүй, ерөнхий журнал, гүйлгээ балансыг бэлтгэхдээ анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв бэлтгээгүй, авлага өглөгийн тооцооны дансыг хөтлөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Монгол Кувейтын байгаль хамгаалах төвийн 2019 оны санхүүгийн тайланд “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 41.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 30.9 сая төгрөгийн алдааг залруулж, 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 10.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Байгаль орчин, амьсгалын сангийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн ба нийт 54.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 54.4 сая төгрөгийн алдааг залруулж, 0.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Төсөл, хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 2 төсөл хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, нийт 23.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өглөө.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцад Агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн санхүүжилтэд 75,221.2 сая төгрөг батлагдсан байна. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны 19/01 тогтоолоор гэр хорооллын айл өрхийг шөнийн тарифын хөнгөлөлтөд хамруулах, бага, дунд оврын халаалтын зууханд шүүх фильтр суурилуулахад дэмжлэг үзүүлэх, сайжруулсан түлш үйлдвэрлэх, түгээх, иргэд худалдан авахад дэмжлэг үзүүлэх, гэр хорооллын нутаг дэвсгэрт агаарын бохирдлын хяналт, мониторинг, туршилт явуулах зэрэг 32 төсөл, арга хэмжээнд 69,738.1 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийх нь зүйтэй гэж үзлээ.

Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн “Аялал жуулчлалын үндэсний төв” ТӨҮГ-ыг татан буулгах Засгийн газрын 2015 оны 310 дугаар тогтоолын хэрэгжилтийг дараагийн аудитаар авч үзнэ.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 11,025 мэдээллийг хугацаанд нь, 1,704 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр зэрэг 20 төрлийн мэдээллийг хэрхэн байршуулсан талаар БОАЖЯ-ны Хяналт-

шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас гаргасан 2019 оны жилийн эцсийн тайлангаас үзэхэд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байдал 86.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн 137.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд буюу зөвлөмжийн хэрэгжилт 74.4 хувьтай байна.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

